

**2022 оны зэргийн шалгалтын бүртгэл хийх тухай**  
**(Тэргүүлэх зэрэг )**

**2022-01-28**

1. Бүртгэлийг цахимаар буюу **Google Forms** ашиглан бүртгэл хийнэ. Иймд эмч бүр өөрийн **gmail** хаягтай байх шаардлагатай ба өөрийн gmail хаягаар орж бүртгүүлнэ.
2. Материалыг бэлнээр хүлээн авахгүй.
3. Бүртгэл 2022 оны 2 сарын 1-нээс 15-ны өдрийн 17 цаг 00 минут хооронд явагдана. (бүртгэлийн холбоосыг 2022-01-31-нд зарлана)
4. Холбогдох материалуудыг **сканердаж** хавсаргана. Үүнд:
  - 4.1. Иргэний үнэмлэхний хуулбар (зөвхөн нүүр тал)
  - 4.2. Мэргэшлийн дипломын хуулбар (резидент төгссөн диплом)
  - 4.3. Эмчлэх эрхийн лизензийн хуулбар
  - 4.4. Мэргэшлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний хуулбар
  - 4.5. 3\*4 хэмжээний фото зураг (сүүлийн 6 сар доторх)
  - 4.6. НДД-ийн хуулбар (эхний зурагтай болон сүүлийн бичлэг бүхий хуудас)
5. Мэргэшлийн зэргийн шалгалтанд орохыг хүссэн хувийн өргөдөл (ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө )
6. Байгууллагын даргын баталгаажуулсан мэргэшлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт (ЭМХТ-ийн захирлын шийдвэрээр батлуулсан загвараар, ЭМХТ-ийн цахим хуудсанд байгааг татаж авч бөглөнө, сканердэж хавсаргана.)
7. Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас дэмжсэн тодорхойлолт (сканердаж хавсаргана)
8. Биелүүлсэн багц цаг. (2017-2019 оны жил тутмын 6 багц цагийн 2/3 нь эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр байх) Гэрчилгээнүүдийг сканердаж хавсаргана.
9. **“Тэргүүлэх” зэргийн тусгай шаардлагыг хангасныг баталгаажуулах баримт бичгүүд.** Үүнд:
  - 9.1. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байх Үүнд: умайг дайвартай дайваргүй, умайн

- хүзүүний дээгүүр болон бүхэлд нь авах мэс засал, өндгөвчийн уйланхай, хавдар (хүндрэлтэй) авах, нөхөн сэргээх мэс засал, эсвэл сорвины жирэмсэн, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хийдэг байна. (Ажлын тайлангаар баталгаажуулах ба тайланг хавсаргана)
- 9.2. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байх (Ажлын тайлангаар баталгаажуулах ба тайланг хавсаргана)
- 9.3. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, дотоод шүүрлийн, охидын болон цэвэршилтийн хамшинж, эмгэг цус алдалтыг оношлох эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байх (Ажлын тайлангаар баталгаажуулах ба тайланг хавсаргана)
- 9.4. Аймаг, дүүрэг, байгууллагын түвшинд оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх чиглэлээр шинэ техник, аргачилал 3-аас доошгүйг эзэмшсэн байх (ажлын баталгаажсан тайлан, он нэр бичих, сканердэж хавсаргана)
- 9.5. Аймаг, дүүрэг байгууллагын түвшинд оношилгоо эмчилгээний гарын авлага, зөвлөмж 3-аас доошгүйг боловсруулсан байх (ажлын баталгаажсан тайлан, гарчиг нүүр нэр оролцсон хэсгийг хувилж сканердэн хавсаргах)
- 9.6. Эзэмшсэн мэргэшлээрээ судалгаа шинжилгээний ажил хийж сүүлийн 5 жилд онол практикийн хуралд 3-аас доошгүй илтгэлийг хэлэлцүүлсэн байх (илтгэлийн хураангуйн хуулбар, сканердэж хавсаргана)
- 9.7. Шавилан сургалтаар 3-аас доошгүй эмчийг дагалдуулан сургасан байх (дагалдуулан сургасан эмчийн нэр, сургасан хугацааг тайланд бичнэ, тайлангаар баталгаажуулна)
10. МЭБЭЭНХ-ны татвар (сүүлийн 3 жилийг тушаасан баримт сканердаж хавсаргана)

МЭБЭЭНХ